

Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд” арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүд угаах орчин (шүд угаах цэг) бүрдүүлээ.

Аймгийн Засаг даргын 2025 оны А/40 захирамжийн хүрээнд хэрэгжиж буй “Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, зөв дадал хэвшүүлэх, өвчлөл бууруулах олон талт үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар болон Монголын шүдний ерөнхий эмч нарын Талст холбоо хамтран “ШҮД УГААЛТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН”-ийг 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулж, Хэрлэн сумын ерөнхий боловсролын нийт 11 сургуулийн 6–8 дугаар ангийн 4027 суралцагчийг амны хөндийн эмгэг илрүүлэх үзлэгт хамруулсан. Тэмцээнд 25 багийн 200 гаруй сурагч идэвхтэй оролцсон байна.

Мөн “Эрүүл шүд” арга хэмжээний 2024–2027 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд, аймгийн Эрүүл мэндийн газар болон хувийн хэвшлийн шүдний 5 эмнэлэгтэй хамтран ерөнхий боловсролын 1 дүгээр ангийн сурагчдыг амны хөндийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд хамруулах чиглэлээр гурвалсан гэрээ байгуулж, 6147 суралцагчийг 100 хувь хамруулсан. Үзлэгийн үр дүнд 1330 сурагчид өвчлөл илэрч, 435 сурагчийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 8457 суралцагч болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 1470 хүүхдэд нийт 25 удаагийн сургалтыг зохион байгуулж, 1500 ширхэг гарын авлага, санамжийг түгээсэн. Хэрлэн сумын цэцэрлэгүүдийн хүүхдүүдийг урьдчилан цаг товлох үйлчилгээнд хамруулж, амны хөндийг эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлсний дүнд 856 гаруй хүүхдийн амны хөндийг бүрэн эрүүлжүүлээд байна. Сургуулийн өмнөх боловсролын нийт 33 байгууллага өдрийн хоолны дараа хүүхдүүдийн шүдийг тогтмол угаалгаж хэвшсэн бол ерөнхий боловсролын 12 сургууль бага ангийн сурагчдын шүд угаах ажлыг эхлүүлээд байна. Шүд угаах цэгийг шинээр бий болгож, сайжруулсан сургуулийн тоо 8 болсон байна.



**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар, Сургалт арга зүйн хэлтэс, 205 тоот

Биологи, эрүүл мэндийн боловсрол хариуцсан

ахлах арга зүйч Э.Эрхэмтөгс


Емэйл: [erkhemtuvs1@moes.edu.mn](mailto:erkhemtuvs1@moes.edu.mn) Утас: 91898883

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан

ахлах арга зүйч Г.Сугар

Емэйл: [sugar.gerelee0819@moes.edu.mn](mailto:sugar.gerelee0819@moes.edu.mn) Утас: 91106324

# Эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа

  
ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР  
Чөлөөтэйг хүндэтгэж, 7 дугаар баг, Хөтөлгөөний  
Дорнод аймаг, 21053, Улаанбаатар, 7054-6938  
Цахим шуудан: [adm@bolovсрол.mn](mailto:adm@bolovсрол.mn)  
Цахим хуудас: [www.bolovсрол.mn](http://www.bolovсрол.mn)

2025.09.18 № 1/573

төвийг \_\_\_\_\_ нэм № \_\_\_\_\_

Хамтран ажиллах тухай

Аймгийн Засаг даргын 2025 оны А/40 захирамжаар "Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн шүдний өвчлөлийн тархалтыг бууруулах, хүүхэд эцэг эх асран хамгаалагч нарын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, зөв дөндөлд сургах, амны хөндийн эмгэг, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн"-ийг 2025 оны 10 сард Монголын шүдний өрөнхий эмч нарын Талст холбоотой хамтран зохион байгуулахаар төлөвлөдөг байна.

Уг тэмцээнд 11-14 насны 200 хүүхдийг 25 баг болгож, баг тус бүр 8 хүүхдийн бүрэлдэхүүнтэй 1 багшийн хамт оролцох юм.


Тус тэмцээнд Хэрлэн сумын 1 дүгээр сургууль - 4 баг, 2 дугаар сургууль - 1 баг, 5 дугаар сургууль - 3 баг, 8 дугаар сургууль - 3 баг, 11 дүгээр сургууль - 2 баг, 12 дугаар сургууль - 3 баг, Хануул сургууль - 3 баг, Шинжэрхжил сургууль - 3 баг, Долоодой сургууль - 1 баг, Флювер сургууль - 1 баг, Баянтүмэн сумын ЕБС-1 баг тус тус бүрдүүлж оролцоно.


Тэмцээнд оролцох хүүхдүүдийн шүд бүрэн, эрүүл байх шаардлагатай тул бид сонгогдсон ЕБС-сургууль дээр 9 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд очиж шүдний эмчийн үзлэг хийж анги болон хүүхдүүдийг сонгож анги удирдсан багш нартай ярилцаж багийг бүрдүүлнэ.

Уг арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр аймгийн ЭМГ-ын сургалтын танхимд сонгогдсон анги бүлгийн анги удирдсан багш нарыг тэмцээний сургагч багш бэлтгэх 2 цагийн сургалтад оролцуулж ажлыг нь зохицуулан бүрэн хамруулна уу.

Жич: Тэмцээнд хүүхдийг сонгохдоо 1 ангиас баг бүрдүүлж оролцовол үр дүнтэй байдаг.

Хүндэтгэсэн,

ДАРГА  Ч. ОЮУНАА

2025.09.18-нийнх 1/573 тоотыг цахимгаар шуудангаас хүргүүлж  
Хөтөлгөөний № 129-г  Бичиг АА



2106302203



**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар, Сургалт арга зүйн хэлтэс, 205 тоот Биологи, эрүүл мэндийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч Э.Эрхэмтөгс  
Емэйл: [erkhemtuvs1@moes.edu.mn](mailto:erkhemtuvs1@moes.edu.mn) Утас: 91898883

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан ахлах арга зүйч Г.Сугар  
Емэйл: [sugar.gerelee0819@moes.edu.mn](mailto:sugar.gerelee0819@moes.edu.mn) Утас: 91106324

Зураг №3 Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн



Зураг №4 Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээний явц

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 472 дугаар тогтоолоор “Дархлаажуулалтын үндэсний товлол”-д багтсан хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтад 11 настай сурагчдыг Эрүүл мэндийн сайдын А/455 дугаар тушаалаар 13 сумын хамрагдвал зохих 11 настай хүүхдүүдийн ХПВ-ийн эсрэг дархлаажуулалтын хамралтын хувь нөлөөллийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 28.4 хувьтай байсан бол нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан ажилласны үр дүнд 11 настай хүүхдүүдийн ХПВ-ийн эсрэг дархлаажуулалтын хамралт 80.1 хувь болсон.

“ХДХВ, ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг угтуулан зохион байгуулсан ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид болон оюутан нийт 3150 хүнийг БЗДХ-ын эрт илрүүлэгт хамруулж, шинээр тэмбүүгийн 4 тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан байна.

### ХПВ-ийн эсрэг дархлаажуулалт

Эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа



ХПВ-ийн эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх сургалт, нөлөөллийн баг ажиллаж буй нь



Мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамрууллаа.

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 61 оюутныг сүрьеэгийн өвчлөлөөс урьдчилан сургалт, нөлөөллийн ажилд хамруулсан. Эрүүл мэндийн үзлэгээр амны хөндий, сүрьеэ, БЗДХ, В,С вирус, ерөнхий биеийн үзлэгт 300 гаруй суралцагч хамрагдсан. Аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн төв, Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран эрүүл мэндийн чиглэлээр 4 сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 610 суралцагчид хамрагдсан.

Дэлхий нийтээр “ХДХВ, ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг угтуулан 1 сарын турш бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг үзлэгийг эрчимжүүлж ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид болон оюутан залуусыг эрт илрүүлэг үзлэгт хамруулсан. Үзлэгт нийт 3150 хүн хамрагдаж шинээр тэмбүүгийн 4 тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан байна.



БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА  
Ч.АРИУНАА ТАНАА

Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай” А/528 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2025 оны А/48 дугаар захирамж “Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний” төслийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 15-аас дээш насны сурагчид болон оюутан залуусыг Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахаар төвлөөд байна.

Иймд хуваарийн дагуу үзлэг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана уу.

Хавсралт 8 хуудастай.

ДАРГА  Ч.АРИУНАА



Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7005:2023 стандартын шаардлагад нийцүүлэх, орон нутгийн болон бусад санхүүжилтийн эх үүсвэрээс шийдвэрлэлээ.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллага 7, ерөнхий боловсролын 13 сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний орчинтой стандартын шаардлага хангаж буй эсэхэд хяналт хийж, зөвлөмж, чиглэл өгч ажилласан.

Дээрх олон улсын хандивлагч байгууллага болон орон нутгийн санхүүжилтээр Хэрлэн сумын хүүхдийн 3, 4, 5, 8, 9, 11, 12, 15, Булган, Чойбалсан, Матад, Халхгол, Чулуунхороот сумын хүүхдийн цэцэрлэгүүд нийт 100.8 сая төгрөгийн 7 нэр төрөл, Хэрлэн сумын 11, Булган сумын сургуулиудад нийт 26.4 сая төгрөгийн 11 нэр төрлийн шаардлагатай тоног төхөөрөмж, Боловсролын яамнаас хэрэгжүүлж буй GPE төслийн хүрээнд Хэрлэн сумын 1, Халхгол, Баян-Уул сумын сургуулиудад 26 төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл тус тус нийлүүлэгдэж хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчинг сайжрууллаа. Жилийн эцсийн байдлаар хоол үйлдвэрлэлийн орчин сайжруулсан цэцэрлэг 13-аар, сургууль 5-аар нэмэгдэж нийт орчин бүрдүүлсэн цэцэрлэг, сургуулийн эзлэх хувь 88.6 болж нэмэгдлээ.

### Хоол үйлдвэрлэлийн орчинтой танилцаж, үйл ажиллагаанд



хяналт хийж байгаа явцаас

**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар, Сургалт арга зүйн хэлтэс, 205 тоот

Биологи, эрүүл мэндийн боловсрол хариуцсан

ахлах арга зүйч Э.Эрхэмтөгс

Емэйл: [erkhemtugs5vs1@moes.edu.mn](mailto:erkhemtugs5vs1@moes.edu.mn) Утас: 91898883

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан

ахлах арга зүйч Г.Сугар

Емэйл: [sugar.gerelee0819@moes.edu.mn](mailto:sugar.gerelee0819@moes.edu.mn) Утас: 91106324